

**“МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2018 ОНД ХӨГЖҮҮЛЭХ  
ҮНДСЭН ЧИГЛЭЛ”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

(2018 оны эхний хагас жилийн байдлаар)

**Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар**

2018-06-22

Улаанбаатар хот

Д/д	Урт болон дунд хугацааны бодлогын баримт бичиг	Зорилт, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин, үр дүн	Зарцуулсан хөрөнгө, эх үүсвэр (тэрбум төгрөг)	Хүрсэн түвшин, хэрэгжилт, хэрэгжилтийн хувь
1	2	3	4	5	6	7
<b>ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ САЛБАРУУДЫН БОДЛОГО</b>						
<b>Зорилт 3. Хөнгөн, хүнсний салбар, жижиг, дунд үйлдвэрлэлийг бодлогоор дэмжинэ.</b>						
3.7	“МУТХҮБ-2030”-ын 2.1.3, Зорилт 1, 4, ЗГҮАХ-ийн 2.58, ЭЗСХ-ийн 1.1.6 дахь заалт	Төрөөс худалдан авах дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх	Худалдан авалтын өсөлтийн хувь	10.0	-	<b>ТӨБЗГ - ХААХ</b> 2018 онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт зохион байгуулах худалдан авах ажиллагааны жагсаалтад дотоодод үйлдвэрлэсэн, чанар стандартын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүн худалдан авах боломж бүхий барааны бүтээгдэхүүний худалдан авах ажиллагаа тусгагдаагүй байна. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2018 оны эхний хагас жилд зарласан нийт 112 тендер шалгаруулалтыг зохион байгуулахдаа дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, дэмжих зорилгоор үндэсний үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэсэн, чанар стандартын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүнийг барилга угсралтын ажилд ашиглахаар бол бараа материал болон ажиллах хүчний хувьд дотоодын давуу эрх тооцохоор тендерийн баримт бичигт тусгасан. 2018 оны эхний хагас жилд гэрээ байгуулсан 30 төсөл, арга хэмжээний тендер
			Нэмэгдүүлэх нэр төрлийн тоо	10		

						шалгаруулалтад хүсэлт ирүүлсэн 21 компанид дотоодын давуу эрх олгосон байна. <b>Өөрийн үнэлгээ:</b> “Тодорхой үр дүнд хүрсэн” – 70% <b>Тэмдэглэл:</b> Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд бүрэн хүрээгүй боловч тодорхой үр дүнд гарсан. Цаашид хэрэгжилт, үр дүнд нэмэгдүүлэх шаардлагатай.
3.8	МУТХУБ-2030-ын 2.1.3, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 1.23 дахь заалт	Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих худалдан авалтын бодлогыг батлан хамгаалах, хил хамгаалах, онцгой байдал, цагдаагийн болон бусад төрийн байгууллагад тууштай хэрэгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	<b>ТӨБЗГ - ХААХ</b> Үндэсний үйлдвэрлэлийг төрийн худалдан авалтаар дэмжих эрх зүйн орчныг сайжруулах талаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар тодорхой асуудлыг тусгаж өгсөн бөгөөд хуулийн төслийг УИХ-д өргөн барьсан ба хэлэлцүүлгийн шатанд байна. <b>Өөрийн үнэлгээ:</b> “Тодорхой үр дүнд хүрсэн” – 70% <b>Тэмдэглэл:</b> Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд бүрэн хүрээгүй боловч тодорхой үр дүнд гарсан. Цаашид хэрэгжилт, үр дүнд нэмэгдүүлэх шаардлагатай.
<b>ТАВ. ЗАСАГЛАЛ, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ, ГАДААД БОДЛОГО, БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРЫН БОДЛОГО</b>						
<b>Зорилт 16. Төрийн өмчийн талаар баримтлах бодлогыг шинэчилж, худалдан авах ажиллагаа, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, стандарт хэмжил зүй, мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагааг сайжруулна.</b>						
16.1	МУТХУБ-2030-ын 2.4, Зорилт 1-2, ЗГҮАХ-ийн 1.1.4, 5.2.1 дэх заалт	Төрийн өмчийн үр ашгийг сайжруулах, Төрийн өмчийг хувьчлах үндсэн чиглэл, бодлогыг шинэчлэх	Баримт бичгийг боловсруулж, батлуулах ажлын явц, хувиар	100	-	<b>ТӨБЗГ – БТУХ</b> Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниуд 2017 онд үйлдвэрлэл санхүүгийн үр ашгийг дээшлүүлж, алдагдалгүй ажиллах зарчмыг баримтлан хэмнэлтийн горимыг хэрэгжүүлж ажилласны үр дүнд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 71.2 хувь нь ашигтай ажилласан байна. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь 2016 онд 4,571.1 тэрбум төгрөгийн орлоготой, 379.9 тэрбум төгрөгийн алдагдалтай байсан бол 2017 оны санхүүгийн тайлан тэнцлийн дүнгээр нийт 7,111.2 тэрбум төгрөгийн орлоготой, 5,932.6 тэрбум төгрөгийн

					<p>зардал гаргаж, 881.7 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад орлого 2,540.1 тэрбум төгрөгөөр буюу 55.6 хувиар, цэвэр ашиг 1,261.1 тэрбум төгрөгөөр буюу 3.3 дахин нэмэгдсэн үр дүнтэй байна.</p> <p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаа, үр ашгийг сайжруулах талаар авах арга хэмжээг боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсний дүнд Засгийн газрын 2018 оны “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай” 08 дугаар тогтоол батлагдсан.</p> <p>Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Улсын Их Хурлын “Төрийн өмчийг 2018-2020 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай” тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газарт 2018 оны 03 дугаар сард хүргүүлсэн. Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу үзэл баримтлалыг Хууль зүй, дотоод хэргийн яам баталсан бөгөөд Засгийн газраас 2018 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн ЗГ-1/112 дугаар албан бичгээр Улсын Их Хуралд өргөн барьсан.</li> <li>- Төрийн өмчит хуулийн этгээдийн үр ашгийг нэмэгдүүлэх, удирдлага, менежмент, бүтэц зохион байгуулалтыг сайжруулах зорилгоор алдагдалтай ажиллаж байсан болон үйл ажиллагаа нь зогссон “Авто замын тоног төхөөрөмжийн түрээс” ТӨХК, “Аж үйлдвэрийн цогцолбор” ТӨХК, “Монгол тамга” ТӨҮГ, “Монгол тариалан” ТӨҮГ, “Монгол мах” ТӨҮГ-ыг татан буулгасан.</li> </ul> <p>Дээр дурдсан Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, төрийн өмчит хуулийн этгээдийн үр ашгийг сайжруулах зорилгоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А-1/350 дугаар албан бичгээр төрийн өмчит хуулийн этгээдэд албан даалгавар, чиглэл өгч ажилласан.</p>
--	--	--	--	--	--

						<p><b>Өөрийн үнэлгээ: “Үр дүнтэй” – 100%</b></p> <p><b>Тэмдэглэл:</b> Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд бүрэн хүрэх боломж бий болсон, удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авсан, үр дүн гарч байгаа.</p>
16.2	МУТХҮБ-2030-ын 2.4, Зорилт 1-2, ЗГҮАХ-ийн 5.2.2 дахь заалт	Худалдан авах ажиллагааны тогтолцоог боловсронгуй болгож, цахим хэлбэрээр зохион байгуулах	Нийт худалдан авалтад цахим худалдан авалтын эзлэх хувь	100	0.18 Улсын төсөв	<p>ТӨБЗГ - ХААХ, МТА</p> <p>Худалдан авах ажиллагааны тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тодорхой асуудлыг тусгасан бөгөөд УИХ-аар хэлэлцэх шатанд байна.</p> <p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь зохион байгуулж буй худалдан авах ажиллагааг 100 хувь цахим хэлбэрээр зохион байгуулж хэвшсэн.</p> <p>Тус газар нь “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем” <a href="https://tender.gov.mn">https://tender.gov.mn</a> –ний үйл ажиллагааг улсын хэмжээнд эрхлэн ажиллаж байна. “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем”-ийн ашиглалтын талаарх улсын хэмжээний тоон үзүүлэлтийг дор танилцуулав:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем” <a href="https://tender.gov.mn">https://tender.gov.mn</a> –нд 1366 захиалагч байгууллага бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 467-оор нэмэгдсэн.</li> <li>2. Улсын хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 2018 оны эхний хагас жилийн байдлаар 19473 төсөл, арга хэмжээ тусгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11775 төсөл арга хэмжээгээр нэмэгдсэн.</li> <li>3. “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем” <a href="https://tender.gov.mn">https://tender.gov.mn</a> -ээр нийт 7217 тендер шалгаруулалтын урилга зарлагдсаны 6218 нь “Цахим тендер шалгаруулалт”-ын урилга байна. Энэ нь нийт урилгын 86.0 хувийг эзэлж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад зарласан нийт урилгын тоо 4846-аар нэмэгдэж, цахим тендер шалгаруулалтын хувь 39 хувиар өссөн байна.</li> <li>4. “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем”-ийн</li> </ol>

					<p>“Цахим шалгалт”-ын дэд системээр 265 шалгалт зохион байгуулагдаж, 4674 иргэн, албан хаагч шалгалт өгсөнөөс 2638 нь тэнцэж, худалдан авах ажиллагааны суурь мэдлэг эзэмшигчийн гэрчилгээ (А3) авсан байна.</p> <p>“Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем”-ийг төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системтэй холбох талаар “Мэдээлэл солилцох гэрээ” байгуулж, тендер шалгаруулалтад шаардлагатай мэдээллийг төрийн байгууллага хороонд шуурхай солилцох арга хэмжээ аван ажиллаж байна.</p> <p><b>Өөрийн үнэлгээ: “Үр дүнтэй” – 100%</b></p> <p><b>Тэмдэглэл: Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд бүрэн хүрэх боломж бий болсон, удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авсан, үр дүн гарч байгаа.</b></p>
--	--	--	--	--	--

Үнэлгээний дүнгийн танилцуулга:

Үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, арга хэмжээний тоо – 4 (ТӨБЗГ-ын дангаар хэрэгжүүлэх 2, хамтран хэрэгжүүлэх 2 заалт) байна. Үүнээс:

- “Үр дүнтэй” буюу 100 хувь - 2 зорилт, арга хэмжээ;
- “Тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70 хувь - 2 зорилт, арга хэмжээ;
- Үндсэн чиглэлийн хэрэгжилтийн дундаж үнэлгээ (хувь) – **85.0 хувь (Үндсэн хэрэгжүүлэгчээр хариуцсан заалтын хэрэгжилт - 100.0 хувь).**

ТАНИЛЦСАН:

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН

ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН

ДАРГА

Б.ГАВАА

ТАЙЛАНГ НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Х.ЭНХЧИМЭГ